



INNOVATION  
INVESTMENT



Pay

# 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

---

Улаанбаатар хот, 2024 он

# Q Pay

*Most accepted payment gateway*



# АГУУЛГА

## 01. КОМПАНИЙН ТУХАЙ

Компанийн тухай  
Түүхэн замнал  
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ  
Гүйцэтгэх удирдлагын баг  
2024 оны хагас жилийн Онцлох үйл явдал

## 02. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Санхүүгийн онцлох тоон үзүүлэлтүүд  
Мэдээлэл технологийн үйл ажиллагаа  
Эрсдэлийн удирдлага  
Нийгмийн хариуцлага

## 03. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлан  
Орлого үр дүнгийн тайлан  
Өмчийн өөрчлөлтийн тайлан  
Мөнгөн гүйлгээний тайлан

## 04. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурал  
Хувьцааны мэдээлэл  
Ногдол ашгийн бодлогын хэрэгжилт  
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, үйл ажиллагаа



INNOVATION  
INVESTMENT



# 01. КОМПАНИЙН ТУХАЙ

*Компанийн тухай*

*Түүхэн замнал*

*Гүйцэтгэх удирдлагын баг*

*Гүйцэтгэх захирлын мэндчилгээ*

*2024 оны хагас жилийн Онцлох үйл явдал*



## 01. КОМПАНИЙН ТУХАЙ



### АЛСЫН ХАРАА

Хүний амьдралыг таатай болгох дижитал шийдэлд хөрөнгө оруулалт хийж, тогтвортой ирээдүйг бүтээх үйлсэд хувь нэмрээ оруулна.



### ЭРХЭМ ЗОРИЛГО

Технологид суурилсан инновацлаг шийдэлд зохистой хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж, шинэ үеийн нийгэм, хүмүүсийн амьдралын хэв маягт нийцсэн дижитал дэд бүтцийг бүрдүүлэх үйлсийг манлайлна.



### ҮНЭТ ЗҮЙЛС

- Тэмүүлэл
- Багийн ажиллагаа
- Хариуцлага
- Ухаалаг
- Тэнцвэртэй байдал
- Хүчтэй түншлэл, харилцаа
- Хэрэгцээг ойлгодог
- Тогтвортой хөгжил



### КОМПАНИ БҮТЭЦ



Инновэйшн Инвестмент ХК нь 2017 оноос эхлэн Технологийн шинэлэг шийдэлд хөрөнгө оруулалт хийх зорилготой гооранхүүсгэн байгуулагдсан.

Одоогоор ҚРАУ үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, удирдах “ККТТ” ХХК, Мерчантуудад чиглэсэн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах “Дижитал мерчант сервис” ХХК гэх 2 охин компанитайгаар үйл ажиллагаа явуулж байна.

### ОХИН КОМПАНИУД



“ККТТ” ХХК нь программ хангамж, мэдээ боловсруулах, техник хангамжийн үйл ажиллагааны чиглэлээр 2010 оны 07 сарын 28 ны өдөр үүсгэн байгуулагдсан.



“Дижитал Мерчант Сервис” ХХК нь 2019 оны 07 сарын 05 ны өдөр үүсгэн байгуулсан бөгөөд тус компани нь Мерчант байгууллагуудад чиглэсэн үйлчилгээ нэвтрүүлэн ажиллаж байна.

## 02. ТҮҮХЭН ЗАМНАЛ

Инновэйшн инвестмент ХК нь 2017 оноос хойш технологийн хурдацтай хөгжилд тулгуурлан иргэдийн өдөр тутмын амьдралын хэв маягийг хялбаршуулж, бэлэн бус төлбөр тооцооны QPay QR төлбөрийн экосистемийн үйлчилгээг нийт үйлчлүүлэгч, харилцагч байгууллагууддаа үзүүлэн мэдээлэл технологийн салбарт шинэчлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэн ажиллаж байна.


**2016**

Хаан банканд анхны нэвтрүүлэлт хийгдэхээр тохиролцож QR код уншуулан гүйлгээ хийх анхны хөгжүүлэлт хийгдэв.


**2017**

Анхны хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхээр группийн толгой компанийг буюу “Инновэйшн Инвестмент” ХК-ийг үүсгэн байгуулав.

**2018**

Төлбөр хүлээн авагч мерчант байгууллага болон Хэрэглэгчийн систем нийлүүлэгчид зориулсан QR нэхэмжлэх үүсгэх боломжтой API-ийн version 2.0 хувилбарыг нэвтрүүлэв.

**2019**

Pos/кассын систем хөгжүүлэлт буюу Хэрэглэгчийн систем нийлүүлэгч компаниудад зориулан шинэчилсэн шинэ POS API хөгжүүлж нэвтрүүлэв.


**2020**

QR нэхэмжлэх үүсгэх мерчантын шинэ API version 2.0 хувилбарыг нэвтрүүлэв

Олон улсын картын Unionpay үйлчилгээтэй хамтын ажиллагааг эхлүүлж картын системд холбогдов


**2022**

Дэлхийн 64 улсад нэвтэрсэн БНХАУ-ын хамгийн өргөн хэрэглээтэй цахим төлбөрийн систем болох олон улсын WechatPay үйлчилгээтэй экосистемийн гэрээ байгуулж Монгол улсдаа анхлан нэвтрүүлэв.


**2023**

Технологийн салбарын анхны IPO-г амжилттай хийлээ


**2024**

Ази, Европын 24 улсад нэвтэрсэн БНСУ-ын №1 цахим төлбөрийн систем болох GLN International-тэй хамтран БНСУ-ын жуулчид эх орондоо хэрэглэдэг төлбөрийн апп-аараа Монголд QPay QR кодыг уншуулан төлбөрөө шууд хийх үйлчилгээг нэвтрүүлэв.



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ,

Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажилладаг түнш байгууллагууд, хүндэтхэрэглэгч та бүхний амгаланг эрэн мэндчилье.

Бид Монгол Улсад анхны мэдээллийн технологийн компанийн IPO-г амжилттай хийснээс хойш хагас жилийн хугацаа өнгөрчээ. Та бүхэнд Инновэйшн Инвестмент ХК-ийн 2024 оны санхүү, үйл ажиллагааны үр дүнгийн талаар тайлагнан мэндчилж байна.

Хагас жилийн туршид динамик, байнга хувьсан өөрчлөгдөж буй зах зээлийн орчинд манай компани стратегийн зорилгодоо тууштай ажиллаж, дасан зохицох чадвараа харуулсан. Санхүүгийн хувьд бид дижитал төлбөрийн шинэлэг шийдлүүд болон зах зээлийг тэлэх стратегийн санаачилгуудыг харилцагч, хамтран ажиллагч түншүүд, ажилтнуудтайгаа хамтран өргөнөөр нэвтрүүлснээр хүчтэй өсөлтийг бий болгож байна. Энэхүү өсөлт нь хувьцаа эзэмшигчдэдээ илүү үнэ цэнийг хүргэх гэсэн бидний зүтгэлийг харуулж байна.

Үйл ажиллагааныхаа хувьд бид инноваци, үйлчлүүлэгчид төвлөрсөн байдал, үйл ажиллагааны шилдэг байдлыг чухалчлан олон улсын дижитал төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран үйлчилгээгээ Өмнөд Солонгос болон Зүүн өмнөд азийн орнуудад амжилттай нэвтрүүлж чадлаа. Бид 2024 онд технологийн тасралтгүй хөгжүүлэлтийг хийж эрхэм үйлчлүүлэгчдэдээ дижитал гүйлгээний хэрэглээ, аюулгүй байдал, үр ашгийг дээшлүүлсэн шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг олгон зах зээлээ улам тэлэхээр зорин ажиллаж байна.

Цаашид бид Инновэйшн Инвестмент компанийн ирээдүйг өөдрөгөөр харж байгаа бөгөөд Дижитал төлбөрийн салбар ч цаашид өргөжин тэлэх хандлагатай байгаа тул бид шинээр гарч ирж буй боломжуудыг ашиглах, хувьсан өөрчлөгдөж буй хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад бэлэн байх болно.

Инновэйшн Инвестмент ХК-д итгэл найдвар тавьж, тууштай дэмжлэг үзүүлсэн эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Мөн шаргуу хөдөлмөр, бүтээлч байдал, хичээл зүтгэлээрээ энэхүү амжилтыг авчирсан хамт олондоо чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлж байна.

Хүндэтгэсэн: *Г. Энх* Гомбодоржийн Эрдэнэмөнх

## 04. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



**Г . ЭРДЭНЭМӨНХ**  
**CEO**

2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа.



**Б . ЭНХБОЛД**  
**CFO**

2021 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Санхүү эрхэлсэн захиралаар ажиллаж байгаа.



**Д . ЖАНЧИВ**  
**СТО**

2021 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Технологи хариуцсан захиралаар ажиллаж байгаа.



**О . ХОНГОР**  
**CBO**

2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захиралаар ажиллаж байгаа.



**Ц . ГОМБОДОРЖ**  
**CISO**

2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захиралаар ажиллаж байгаа.



**С . ГҮРЖАВ**  
**“ДИЖИТАЛ МЕРЧАНТ СЕРВИСЭС” ХХК**  
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**


2019 оноос “Дижитал Мерчант Сервисэс” ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байгаа.

## 05. 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

### GLN QPAY ХАМТЫН АЖИЛЛАГАА



Олон улсын төлбөрийн системийн сүлжээ болох БНСУ дахь GLN компанитай хамтран БНСУ-ын иргэдийн өдөр тутамд ашигладаг төлбөрийн аппликэйшнаас QPAY QR код уншуулан төлбөр хүлээн авах боломжийг нэвтрүүлэхээр зорьж “БНСУ-ын төлбөрийн систем Монголд” нээлтийн арга хэмжээг 2024 оны -03р сарын -29ний өдөр зохион байгуулж 06 дугаар сарын -01ний өдөр системийн түвшинд амжилттай нэвтрүүлж ажиллалаа.



Уг хамтын ажиллагааны хүрээнд GLN компаниас төлөөлөгчид ирж УБ хот болон жуулчдын ихээр зорчдог Тэрэлж орчмоор туршилтын гүйлгээнүүдийг хийж тестийн орчныг амжилттай давснаар 2023 онд төлөвлөсөн байсан зорилгодоо эхний хагас жилийн хугацаанд хүрч ажилласан байна.

### WECHATPAY ТӨЛБӨРИЙН СИСТЕМ



Үнэт цаас гаргагч нь БНХАУ-ын хамгийн өргөн хэрэглээтэй төлбөрийн аппликэйшн болох WECHAT PAY үйлчилгээг нэвтрүүлснээс хойш багагүй хугацаа өнгөрсөн ба Монгол улсын Гадаадын Иргэн Харьяатын Газарын цахим үйлчилгээнд системийн холболт хийж Монгол улс руу зорчих цахим виз, оршин суух эрх зэрэг түгээмэл авдаг үйлчилгээний төлбөрийг цахимаар шийдсэнээр гадаадын иргэдэд орон цай, цаг хугацаа хамаарахгүйгээр үйлчилгээ авах нөхцөлийг бодитойгоор бүрдүүлэн ажиллаж байна.

2024 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор нийт 27 мянга гаруй гадаадын иргэдийн Монгол улсад амьдрах болон Монгол улс руу зорчих үйлчилгээний төлбөрийг хялбараар шийдсэн байна.



## 05. 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

### ХЭРЭГЛЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН НЭГДСЭН ПЛАТФОРМ БОЛОХ ВРАУ ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЭВ



Үнэт цаас гаргагч нь Төрийн банк ХК-тай хамтран Төрийн банкны системд бүртгэлтэй СӨХ, Контор, Цахилгаан түгээх байгууллагууд болон бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын системийг нэгтгэн финтек аппликэйшнууд болон банкны аппликэйшнуудад нэвтрүүлж тэдгээрийн хэрэглэгчдэд хэрэглээний төлбөрөө төлөх боломжийг илүү ойртуулах томоохон ажлын хүрээг эхлүүллээ.

ВРАУ үйлчилгээг өнөөдрийн байдлаар Гэрэгэ компанийн +270 киоскуудад нэвтрүүлсэн ба МонРАУ, РосКЕТ, Токи зэрэг хэрэглэгчдийн өдөр тутамдаа ашигладаг аппликэйшнуудад холбож нэвтрүүлэх ажлууд үргэлжлэн хийгдэж байна.

### EASY INVOICE ШИНЭ ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЛЭЭ



Үнэт цаас гаргагчийн QPAU үйлчилгээ нь бүх төрлийн үйлчилгээний байгууллагуудад нэвтэрсэн ба онлайн худалдааны салбарт буюу FACEBOOK сошиал орчинд худалдаа хийж байгаа байгууллага болон хувь хүмүүсийн бизнест бодитой дэмжлэг болохоор төлбөрийн нэхэмжлэхийг гар утасны дугаарт мессеж хэлбэрээр илгээх, төлбөр хянах мэдэгдэл бүхий цоо шинэ үйлчилгээг нэвтрүүллээ.

### ОЛОН УЛСЫН ТӨЛБӨРИЙН КАРТЫН PCI DSS СТАНДАРТЫГ ШААРДЛАГЫГ ХАНГАВ



Картын мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS стандартын шаардлагыг бүрэн ханган БНЭУ-ийн SISA байгууллагаар дөрөв дэх жилдээ амжилттай баталгаажилт хийлгэв. Энэ хүрээнд жилд 4 удаагийн эмзэг байдлын үнэлгээ хийлгэн, картын мэдээллийг аюулгүй, нууцлалтай хадгалах, дамжуулах ажлыг тухай бүр хийж ажилласан.



## 05. 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

### ТОКЕН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЕРВИС



2023 оны -06р сард хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж эхлүүлж байсан Монголбанкны Token Үйлчилгээний Сервис (ТҮС)-ийг түншлэгч банкуудад холбож нэвтрүүлэх ажлуудыг амжилттай зохион байгуулж байна. Ингэснээр банкны харилцагч өөрийн ашигладаг төлбөрийн биет картын ТҮС үйлчилгээгээр аливаа воллет аппликэйшнд цахимжуулан хадгалж QR төлбөр тооцоонд ашиглах боломж нээгдэх юм.

### ISO 27001:2013 СТАНДАРТЫН БАТАЛГААЖИЛТЫГ ХАНГАВ



Олон улсын Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 27001:2013 стандартыг Франц улсын Афнор байгууллагаар амжилттай баталгаажилт хийлгэн 2024 оны 04 дүгээр сарын -24ний өдөр гэрчилгээ хүлээн авсан. Стандартын хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын тогтолцооны шаардлагыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөн ажиллаж байна.



INNOVATION  
INVESTMENT



## 02. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

*Санхүүгийн онцлох тоон үзүүлэлтүүд*


*Мэдээлэл технологийн үйл ажиллагаа*

*Эрсдэлийн удирдлага*


*Нийгмийн хариуцлага*

# 01. САНХҮҮГИЙН ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ГҮЙЛГЭЭНИЙ ТОО  
/САЯ.ШИРХЭГ/







ГҮЙЛГЭЭНИЙ ҮНИЙН ДҮН  
/ИХНАЯД ТӨГРӨГ/



2024 оны эхний хагас жилд 4.4 их наяд төгрөгийн 76 сая ширхэг гүйлгээг QRay-ээр дамжуулснаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад гүйлгээний тоо 48 хувийн өсөлт харин гүйлгээний үнийн дүн 78 хувийн өсөлт үзүүлсэн байна.


## ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ БА ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2024 он бол гүйлгээний тоо, гүйлгээний үнийн болон борлуулалт зэрэг бүхий л статистик үзүүлэлтийн хувьд өндөр өсөлттэй жил байлаа. Гүйлгээний дүн, гүйлгээний тоо, зэрэг статистик үзүүлэлтүүдийг доорх байдлаар тодруулан бэлтгэлээ.




## 02. САНХҮҮГИЙН ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### БОРЛУУЛАЛТ




2024 оны хагас жилийн Борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 102 хувь, нийт ашиг 87хувь, цэвэр ашиг 124 хувийн өсөлтийг тус тус үзүүлсэн нь өртөг болон үйл ажиллагааны зардлын хяналт сайн буюу ашгийн түвшнийг тогтмол өндөрт барьж чадлаа.

### НИЙТ АШИГ /САЯ.ТӨГРӨГ/




### ЦЭВЭР АШИГ /САЯ.ТӨГРӨГ/




“Нийт ашиг” болон “цэвэр ашгийн” түвшин 2024 оны эхний хагас жилийн хувьд тус тус 59 хувь ба 48 хувь байгаа нь үндсэн үйл ажиллагааны ашгийн түвшин маш сайн байгааг харуулж байна.

### НИЙТ ХӨРӨНГӨ /САЯ.ТӨГРӨГ/




### ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН /САЯ.ТӨГРӨГ/



2021 оны эхний хагасаас 2024 оны эхний хагасын хооронд нийт хөрөнгө болон эздийн өмч тогтмол өсч тус 4 жилийн хугацаанд /CAGR/ буюу жилийн нийлмэл өсөлтийн дундаж түвшин 71 хувь бөгөөд 2024 оны эхний хагасын байдлаар нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 98 хувь өссөн бол эздийн өмч өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн байна.

## 02. САНХҮҮГИЙН ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### ТӨСӨВ БА ГҮЙЦЭТГЭЛ



2024 оны эхний хагасын төсөв ба гүйцэтгэлийн харьцуулалт:

- Нийт хөрөнгийн дүн 21,1 тэрбум төгрөгт хүрч төсвийн биелэлт 142 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Борлуулалтын дүн 10,9 тэрбум төгрөг гарсан бөгөөд төлөвлөгөөг 32 хувиар давуулан биелүүлсэн байна
- Цэвэр ашиг 5.3 тэрбум төгрөг гарч төлөвлөгөөний биелэлт 152 хувийн гүйцэтгэлтэй байна.

## 03. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

QPay бизнест шаардлагатай программ хангамжийн судалгаа, хөгжүүлэлт, тогтвортой үйл ажиллагааг тасралтгүй хангах чиг үүргийн дагуу харилцагч болон мерчант, бусад нэгжүүдийн захиалгаар программ хангамжийн шаардлага боловсруулах, систем анализ хийх, хөгжүүлэлт хийх, чанарын хяналт хийх, нэвтрүүлэх гэх мэт төрөл бүрийн шаардлага бүхий мэдээллийн систем, программ хангамжуудыг амжилттай хөгжүүлэн нэвтрүүлж, засвар үйлчилгээ, хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна.

### 2024 оны эхний хагас жилийн хугацаанд дараах онцлох ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- QPay P2P болон Картын гүйлгээний тайлангийн модуль

QPay merchant web, QPay fiadmin, QPay vendor web системүүдэд банк, мерчант, вендорууд өөрийн P2P болон Картын гүйлгээний тайланг хурдан бөгөөд дэлгэрэнгүйгээр татаж авах боломж бий болсон.

- QPay вендор веб систем

QUICK QR үйлчилгээг хүлээн авагч вендор байгууллагууд өөрийн элсүүлсэн мерчантууд дээр гарсан гүйлгээ, мерчантын тоо зэрэг мэдээллүүдийг энэхүү системээр дамжуулан өөрсдөө удирдах бүрэн боломжтой болсон.

- SocialPay QR -г Qpay унших

Өмнөх онд Голомт банкны SocialPay app -р Qpay QR буюу Qpay мерчантууд дээрх QR -г уншуулан гүйлгээ хийх холболтыг хийсэн. Харин 2024 оны эхний хагас жилд нэмэлтээр Голомт банкны QR-г Qpay уншиж гүйлгээ хийх хөгжүүлэлтийг хийж бүрэн нэвтрүүлсэн. Ингэснээр Qpay нэвтэрсэн бүх банкны апп болон wallet, fintech апп-ууд голомт банкны мерчантын QR -г унших боломж бүрдсэн.

- Олон улсын төлбөр тооцоо (GLN)

2024 оны 6 дугаар сард Send.mn-тэй хамтарч Солонгос улсын GLN компанитай системийн холболт, хөгжүүлэлтийг хийж дууссан.

- Нөөц датацентрийн төлөвлөлт хийв.

Qpay төлбөрийн систем бүхэлдээ эсвэл зарим бүрдэл хэсгүүд бодит цагийн горимоор болон гар аргаар нөөц датацентр лүү шилжин ажиллах техникийн төлөвлөлтийг боловсруулсан. Мөн нөөц датацентрийг өөр байршилд шилжүүлэх судалгааг хийв. Үндсэн болон нөөц датацентрийн хоорондох сүлжээний холболтын найдвартай байдлыг хангах, Монголбанкны шаардлагад нийцүүлэх төлөвлөлтийг хийж шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах захиалгыг хийв.



- Түр дансны хөгжүүлэлт

QRay v2 мерчант банкнаас элсүүлэх процесст түр данс тохируулах, тухайн харилцагч банк өөрөө мерчантад хаалт хийх тохиргоо, мөн шимтгэл хуваарилах зарчмын тохиргоог программ хангамжийн хүрээнд бүрэн хийж дуусгасан.

- Суурь дэд бүтцийн шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлж байна.

QRay төлбөрийн системийн найдвартай байдлыг хангах хүрээнд суурь дэд бүтцийн шинэчлэл хийх судалгаа хийж 4 төрлийн шийдэл боловсруулсан. Суурь дэд бүтцийн шийдэл тус бүрийн харьцуулсан үнэлгээ хийж HPE dHCI шийдлийг худалдан авах захиалга хийгээд байна. Тухайн тоног төхөөрөмж, программ хангамжийн цогц шийдлийг нэвтрүүлснээр QRay төлбөрийн системийн найдвартай ажиллагаа сайжирна. Өгөгдөл, мэдээллийн өсөлтийг тооцон ирэх 5 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөж байна. Энэхүү дэд бүтцийн цогц шийдэл рүү 2024 онд бүрэн шилжихээр төлөвлөн ажиллаж байна.

## 04. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, дүрэм, эрх зүйн актад нийцүүлэн батлагдсан Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, холбогдох журам зааврууд, Эрсдэлийн удирдлагын бодлого журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлан ажиллаж байна.

- Үнэт зүйлийг бий болгох, хамгаалах: Компанийн зорилго, зорилтод хүрэх, гүйцэтгэлээ сайжруулах үйл ажиллагааны чухал хэсэг байна.
- Шийдвэр гаргалтын салшгүй хэсэг байх: Компанийн удирдлагын зүгээс аргаэмжээгэрэмбэлэнтөлөвлөх, сонголтхийхэддэмжлэгүзүүлдэг байна.
- Нөхцөл байдалдаа тохирсон байх: Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь эрсдэлийн мөн чанар, эх үүсвэрт тохирсон байна.
- Ил тод, оролцоог хангасан байх: Компанийн бүх түвшний шийдвэр гаргагчдын оролцоог хангасан мэдээллийн урсгал нээлттэй байна.
- Байнга сайжирдаг байх: Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдлыг тогтмол хянаж, тасралтгүй сайжруулдаг байна.

## 05. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

### БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

“Инновэйшн Инвестмент” ХК нь бүх шатны үйл ажиллагаандаа Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Тогтвортой Хөгжлийн зорилтуудыг 2020 оноос хойш хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд “Инновэйшн Инвестмент” ХК нь өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан байгаль орчин, нийгэм эдийн засагт эерэг нөлөөлөл бий болгох, дотоод үйл ажиллагаагаа байгаль, нийгэмд ээлтэй болгохоор зорин ажиллаж байна.



“Инновэйшн Инвестмент” ХК нь өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан байгаль орчин, нийгэм эдийн засагт эерэг нөлөөлөл бий болгох, дотоод үйл ажиллагаагаа байгаль, нийгэмд ээлтэй болгохоор зорин ажиллаж байна. “Инновэйшн Инвестмент” ХК-ийн байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн бодлогын чиглэл нь тогтвортой бизнесийн үйл ажиллагааг явуулах, нийгэм, байгаль орчны асуудлуудад анхаарал хандуулах, тогтвортой, сэтгэл ханамжтай ажлын байрыг бий болгох юм.

### БАЙГАЛЬ, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТУХАЙ

“Инновэйшн Инвестмент” ХК-аас үзүүлдэг Qpay үйлчилгээ нь цахим төлбөрийн хэрэгслийг хялбар болгож, QR төлбөр тооцоог хүн бүрд нээлттэй болгон ойртуулсан билээ. Энэхүү үйлчилгээний

нөлөөллөөр Хэрэглэгчид банкны урт дараалалд зогсолгүй цахим QR гүйлгээгээр төлбөрөө гүйцэтгэх болсон. Хэрэглэгчийн тоо нэмэгдэх хэрээр цаг хугацаа, шаардлагагүй зардал болон хог хаягдал буурж, бүх талуудын сэтгэл ханамж өсөж байна.

Банкны 1 гүйлгээний ард 1 ширхэг А4 цаас ашиглагддаг гэж үзвэл Qpay үйлчилгээ нь 2024 оны эхний хагас жилд зөвхөн төрийн үйлчилгээний хувьд 1,065,904 ширхэг цаас хэмнэснээр 128 мод, 393 тонн ус, 18м<sup>3</sup> нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг тус тус хэмнэсэн байна.

“Инновэйшн Инвестмент” ХХК нь Qpay үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нэвтрүүлснээс хойш доорх хэмнэлтүүдийг бий болгож цахим төлбөр тооцооны шинэ соёлыг нэвтрүүлжээ.

**НИЙТ QRAУ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛЖ БАЙГАЛЬ  
ОРЧИНД ҮЗҮҮЛСЭН ЭЭРЭГ НӨЛӨӨ**

**75,913,840  
ЦААС**

**9,110  
МОД**

**27,934  
ТОНН УС**

**1,309m<sup>3</sup> CO<sup>2</sup>  
ЯЛГАРУУЛАЛТ**
**НИЙТ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛЖ БАЙГАЛЬ  
ОРЧИНД ҮЗҮҮЛСЭН ЭЭРЭГ НӨЛӨӨ**
**1,065,904  
ЦААС**
**128  
МОД**
**393  
ТОНН УС**
**18m<sup>3</sup> CO<sup>2</sup>  
ЯЛГАРУУЛАЛТ**
**БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛ**

“Инновэйшн Инвестмент” ХК нь байгууллагын засаглалын тогтвортой байдалд дараах үзүүлэлтүүдийг баримталж байна.

- “Инновэйшн Инвестмент” ХК нь засаглалын хүрээнд удирдлагын бүтэц, зохион байгуулалт, бодлого, тогтолцоонуудыг оновчтой, зөв зохистой, болгон бүрдүүлж хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байгаа бөгөөд нэн тэргүүнд үнэн, зөв мэдээллээр удирдлагыг цаг алдалгүй хангаж, шийдвэр гаргалтыг бодитой, оновчтой, шуурхай, зөв зохистой болгох механизмыг бүрдүүлж, ил тод, нээлттэй, өндөр хариуцлагатай гүйцэтгэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бий болгон бэхжүүлэх чиглэлээр сайжруулалт хийн ажиллаж байна.
- “Инновэйшн Инвестмент” ХК нь цалин, урамшууллын тогтвортой байдлыг хангахын тулд ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох журмыг бэлтгэн нэвтрүүлэхээр ажиллаж байна.
- Мэдээллийн аюулгүй байдлын чанарыг сайжруулж дотоод үйл ажиллагаандаа ISO:27001 стандартыг нэвтрүүлсэн бөгөөд харилцагчийн мэдээллийг хамгаалах найдвартай байдлыг хангах зорилгоор олон улсын төлбөр тооцооны хэрэгсэлд тавигддаг PCI:DSS стандартыг нэвтрүүлээд байна.



INNOVATION  
INVESTMENT



Pay

## 03. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

*Санхүү байдлын тайлан*

*Орлого үр дүнгийн тайлан*

*Өмчийн өөрчлөлтийн тайлан*

*Мөнгөн гүйлгээний тайлан*

# 01. САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

<i>МЯНГАН ТӨГРӨГӨӨР</i>	2023.12.31	2024.06.30
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	13,999,820	14,619,477
Дансны авлага	1,427,598	2,015,785
Татвар, НДШ-ийн авлага	14,611	7,478
Бусад авлага	415,741	943,631
Бусад санхүүгийн хөрөнгө	1,924,531	994,833
Бараа материал	2,020	3,780
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	80,549	652,815
Эргэлтийн хөрөнгийн дүн	17,864,869	<b>19,237,798</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	624,074	611,494
Биет бус хөрөнгө	216,070	208,239
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	1,000,000
Хойшлогдсон татварын хөрөнгө	58,711	77
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	898,855	1,819,810
<b>Нийт хөрөнгө</b>	<b>18,763,724</b>	<b>21,057,609</b>
<b>ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>Эргэлтийн өр төлбөр</b>		
Дансны өглөг	805,601	2,631,187
Цалингийн өглөг	37,543	34,002
Татварын өр	433,808	462,370
НДШ-ийн өглөг	393	321
Хүүний өглөг	23	-
Урьдчилж орсон орлого	1,800	1,800
Богино хугацаат өр төлбөр	617	800
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,279,784</b>	<b>3,130,479</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Хойшлогдсон татварын өр	-	8,225
Бусад урт хугацаат өр төлбөр	36,372	14,352
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>36,372</b>	<b>22,577</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,316,156</b>	<b>3,153,056</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>		
Хувьцаат капитал	4,425,440	4,312,705
Нэмж төлөгдсөн капитал	4,653,188	3,776,735
Хуримтлагдсан ашиг	8,368,939	9,815,113
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>17,447,568</b>	<b>17,904,553</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>18,763,724</b>	<b>21,057,609</b>

## 02. ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

МЯНГАН ТӨГРӨГӨӨР	2023.12.31	2024.06.30
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>13,237,510</b>	<b>10,947,430</b>
Борлуулалтын өртөг	6,041,015	4,472,239
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>7,196,496</b>	<b>6,475,192</b>
Хүүний орлого	414,802	896,969
Ногдол ашгийн орлого	-	69,105
Бусад орлого	1,210,184	-
Борлуулалт, маркетингийн зардал	564,484	184,319
<b>Ерөнхий ба удирдлагын зардал</b>	<b>1,698,693</b>	<b>846,008</b>
Санхүүгийн зардал	12,897	1,784
Бусад зардал	161,084	643
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(4,164)	(24,966)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	74	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>6,380,232</b>	<b>6,383,545</b>
Орлогын татварын зардал	684,069	1,108,483
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>5,696,163</b>	<b>5,275,062</b>

## 03. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

МЯНГАН ТӨГРӨГӨӨР	Хувьцаат Капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>4,425,440</b>	<b>4,653,188</b>	<b>8,368,939</b>	<b>17,447,568</b>
Өмчид гаргасан өөрчлөлт	(112,735)	(876,453)	-	(989,188)
Зарласан ногдол ашиг	-	-	(3,828,891)	(3,828,891)
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	5,275,065	5,275,065
<b>2024 оны 06-р сарын 30-ээрх үлдэгдэл</b>	<b>4,312,705</b>	<b>3,776,735</b>	<b>9,815,113</b>	<b>17,904,553</b>



## 04. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

МЯНГАН ТӨГРӨГӨӨР		2023.12.31	2024.06.30
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Мөнгөн орлогын дүн		14,678,301	11,459,619
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого		13,761,945	11,394,144
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		35	233
Буцаан авсан албан татвар		47,795	-
Бусад мөнгөн орлого		868,525	65,243
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>11,709,895</b>	<b>9,667,579</b>
<b>Ажиллагчдад төлсөн</b>		<b>1,279,773</b>	<b>608,848</b>
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		340,015	174,121
Бараа материал худалдан авахад төлсөн		9,472	5,128
Ашиглалтын зардалд төлсөн		-	3,079
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		157	204
Татварын байгууллагад төлсөн		1,668,329	2,492,057
Даатгалын төлбөрт төлсөн		2,813	-
Бусад мөнгөн зарлага		8,409,338	6,384,142
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>2,968,406</b>	<b>1,792,040</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>		<b>4,452,376</b>	<b>2,114,067</b>
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		3,992,456	414,630
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		46,916	1,378,241
Хүлээн авсан хүүний орлого		413,004	255,546
Хүлээн авсан ногдол ашиг		-	65,649
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>3,882,164</b>	<b>3,700,328</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		81,032	772,680
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-	40,000
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		3,653,247	1,515,904
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		147,885	1,371,745
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>570,212</b>	<b>(1,586,262)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Мөнгөн орлогын дүн		8,747,873	3,844,425
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		10	99,425
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		8,747,864	3,745,000
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>136,283</b>	<b>3,422,159</b>
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		136,283	29,357
Төлсөн ногдол ашиг		-	3,392,803
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		<b>8,611,591</b>	<b>422,265</b>
Валютын ханшийн зөрүү		(3,748)	(8,387)
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>12,146,460</b>	<b>(619,657)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>1,853,360</b>	<b>13,999,820</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>13,999,820</b>	<b>14,619,477</b>



INNOVATION  
INVESTMENT



## 04. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

*Хувьцаа эзэмшигчдийн хурал*

*Хувьцааны ханш*

*Ногдол ашгийн бодлогын хэрэгжилт*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, үйл ажиллагаа*

## КОМПАНИ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:

**QRAY**

Хэлбэр:

**Хувьцаат компани**

Регистрийн дугаар:

**6183948**

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгуулага:

**Монголын Хөрөнгийн бирж**

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:

**III**

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:

**184,889,160**

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:

- Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
- Программ хангамжийн үйлчилгээ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцааны эзэмчигчдийн бүтэц:




## 01. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Инновэйшн Инвестмент ХК нь IPO хийсний дараах хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурлаа 2024 оны 4 дүгээр сарын -28ний өдөр хийсэн. Тус хурлаар Компанийн жилийн үйл ажиллагааны болон аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт батлах, Хувьцаат компанийн дүрмийн төслийг батлах болон ТУЗ-ийн гишүүдийг шинээр томилох үндсэн асуудлуудыг баталж шийдвэр гаргасан.

## 02. ХУВЬЦААНЫ ХАНШ

2024 оны эхний хагас жилд 522,573 ширхэг хувьцаа 115,834,747.84 төгрөгөөр арилжигдсан бөгөөд нийт 6 сарын хугацаандах дундаж арилжааны ханш 221.66 төгрөг байлаа.



2024 оны 6 дугаар сарын 30ны өдрийн ханш 230 төгрөгөөр хаагдсан бөгөөд Компанийн үнэлгээ 42.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

## 03. НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭ

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ 2 САРЫН 15НЫ ӨДРИЙН 02/02 ТООТ ТОГТООЛООР 2023 ОНЫ ЦЭВЭР АШГИЙН 70.2 /ДАЛ АРАВНЫ ХОЁР/ ХУВЬ БУЮУ 4,000,000,000.00 /ДӨРВӨН ТЭРБУМ/ ТӨГРӨГИЙН НОГДОЛ АШГИЙГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ХУВААРИЛАХААР ШИЙДВЭРЛЭСЭН.**

**БҮРТГЭЛИЙН ӨДӨР БУЮУ 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 8НЫ ӨДРИЙН БАЙДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИЖ БАЙСАН НИЙТ 1,231 ШИРХЭГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН НОГДОЛ АШГИЙГ ҮЦТХТ ДЭХ ҮНЭТ ЦААСНЫ ДАНСАНД 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 15НЫ ӨДӨР БҮРЭН ХУВААРИЛЖ ОЛГОСОН.**

## 04. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн дүрэмд нийцүүлэн ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн буюу нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосон. Мөн 2024 оны 05 дугаар сарын -27ны өдөр хувьцаат компанийн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ийг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Тус журамд ТУЗ-ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн хурал, хуралдах журам, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байдаг.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-ийн дэргэд дор дурдсан хороод ажиллаж байна. Үүнд:

1. Аудитын хороо
2. Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо
3. Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



**А.БАТТАМИР**  
ТУЗ-ийн дарга



**Б.ЧУЛУУНСҮХ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн




**У.НАРАНБААТАР**  
ТУЗ-ийн ердийн гишүүн



**Г.ХАТАНБОЛД**  
ТУЗ-ийн ердийн гишүүн



**Б.АНХБОЛД**  
ТУЗ-ийн ердийн гишүүн




**У.МӨНХЗУЛ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн



**Д.ГАНЗОРИГ**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн



**Т.ДАШЦЭРЭН**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн



**Ш.УЯНГА**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн



**INNOVATION  
INVESTMENT**



*Вэб хуудас: I-INVESTMENT.MN*

*Холбоо барих: +976 76102211*

*И-мэйл хаяг: INFO@QPAY.MN*

*Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар  
дүүрэг, 1-р хороо, Элчингийн гудамж, Шүрэн  
оффис, 6 тоот*



*Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт*

**Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/**

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.*

Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: Инновэйшн Инвестмент УБ-ийн гэрчилгээний дугаар: 9019097177 Үнэт цаасны код: QPAУ Утасны дугаар: 76102211
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Мэдээлэл технологийн үйл ажиллагаа Программ хангамжийн үйлчилгээ
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	184,889,160 ширхэг
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Санхүү эрхэлсэн захирал Б.Энхболд

**I. Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/**

Санхүүгийн байдлын үзүүлэлт	<b>Үзүүлэлт</b>	<b>2023 он /мян.төг/</b>	<b>2024/06/30 /мян.төг/</b>
	<b>Хөрөнгө</b>		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	17,864,869	19,237,798
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	898,855	1,819,810
	<b>Нийт хөрөнгө</b>	<b>18,763,724</b>	<b>21,057,609</b>
	<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
	Богино хугацаат өр төлбөр	1,279,785	3,130,479
	Урт хугацаат өр төлбөр	36,372	22,577
	<b>Нийт өр төлбөр</b>	<b>1,316,156</b>	<b>3,153,056</b>
	Эздийн өмчийн дүн	17,447,568	17,904,553
	<b>Нийт өр төлбөр болон эздийн өмчийн дүн</b>	<b>18,763,724</b>	<b>21,057,609</b>

Орлогын тайлан	Үзүүлэлт	2023 он /мян.төг/	2024/06/30 /мян.төг/
	Борлуулалтын орлого	13,237,510	10,947,430
	Өртөг	(6,041,015)	(4,472,239)
	<b>Нийт ашиг/(алдагдал)</b>	<b>7,196,496</b>	<b>6,475,192</b>
	Борлуулалт, маркетингийн зардал	(564,484)	(184,319)
	Ерөнхий удирдлагын зардал	(1,698,693)	(846,008)
	<b>Орлогын татварын өмнөх ашиг/(алдагдал)</b>	<b>6,380,232</b>	<b>6,383,545</b>
	Орлогын татварын зардал/(буцаалт)	(684,069)	(1,108,483)
	<b>Тайланг жилийн ашиг/(алдагдал)</b>	<b>5,696,163</b>	<b>5,275,062</b>
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	Нийт /мян.төг/	
	2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	17,447,568	
	Тайланг жилийн ашиг	5,275,065	
	Бусад өөрчлөлт	(4,818,079)	
	2024 оны 6 дугаар сарын 30-ны үлдэгдэл	17,904,553	
Мөнгөн гүйлгээний тайлан	Үзүүлэлт	2023 он /мян.төг/	2024/06/30 /мян.төг/
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,968,406	1,792,040
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	570,211	(1,586,262)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,611,591	422,265
	Валютын ханшийн зөрүү	(3,748)	(8,387)
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	12,146,460	619,657
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,853,360</b>	<b>13,999,820</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>13,999,820</b>	<b>14,619,477</b>
	Тайланг хавсралтаар хүргүүлэв.		
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		

	<p>Иновэйшн Инвестмент ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, санхүүгийн баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ болон өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан заавар, журам аргачлал, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тайлагнасан болохыг танилцуулж байна. Монголын төлбөр тооцооны зах зээлд өөрсдийн байр сууриа бэхжүүлж, олон улсын зах зээлд үйлчилгээгээ нэвтрүүлж байгаа явдал нь цаашид тогтвортой хөгжих суурийг сайн тавьсан гэж үзэн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооноос 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагааг хангалттай сайн гэж дүгнэж байна.</p>																	
3.	<p>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</p>																	
3.1.	<p>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</p>	<table border="1"> <thead> <tr> <th>Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд</th> <th>2023</th> <th>2024/06/30</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Нийт ашгийн хувь</td> <td>54%</td> <td>59%</td> </tr> <tr> <td>Цэвэр ашгийн хувь</td> <td>43%</td> <td>48%</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж</td> <td>33%</td> <td>29%</td> </tr> <tr> <td>Нэгж хувьцаанд ногдох ашиг</td> <td>30.81</td> <td>28.53</td> </tr> </tbody> </table>	Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд	2023	2024/06/30	Нийт ашгийн хувь	54%	59%	Цэвэр ашгийн хувь	43%	48%	Өөрийн хөрөнгийн өгөөж	33%	29%	Нэгж хувьцаанд ногдох ашиг	30.81	28.53	
Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд	2023	2024/06/30																
Нийт ашгийн хувь	54%	59%																
Цэвэр ашгийн хувь	43%	48%																
Өөрийн хөрөнгийн өгөөж	33%	29%																
Нэгж хувьцаанд ногдох ашиг	30.81	28.53																
3.2.	<p>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</p>	<table border="1"> <thead> <tr> <th>Хөрвөх чадварын харьцаа</th> <th>2023</th> <th>2024/06/30</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Эргэлтийн харьцаа</td> <td>13.96</td> <td>6.15</td> </tr> <tr> <td>Түргэн хөрвөх чадварын харьцаа</td> <td>13.96</td> <td>6.14</td> </tr> <tr> <td>Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа</td> <td>7.54%</td> <td>17.61%</td> </tr> </tbody> </table>	Хөрвөх чадварын харьцаа	2023	2024/06/30	Эргэлтийн харьцаа	13.96	6.15	Түргэн хөрвөх чадварын харьцаа	13.96	6.14	Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	7.54%	17.61%				
Хөрвөх чадварын харьцаа	2023	2024/06/30																
Эргэлтийн харьцаа	13.96	6.15																
Түргэн хөрвөх чадварын харьцаа	13.96	6.14																
Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	7.54%	17.61%																
3.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p>Бидний хувьд хэрэглэгчид, мерчант байгууллагууд болон банк, санхүүгийн байгууллагуудын хэрэгцээ, шаардлагад нийцүүлж бүтээгдэхүүн үйлчилгээгээ тухай бүр сайжруулж, шинэ хөгжүүлэлтүүдийг хийн ажиллаж байна. Мөн монголын бүх арилжааны банкуудад нэвтэрсэн тул дотоодын QR төлбөр тооцооны зах зээлийг бүрэн хамарч ажиллаж байна. Үүнээс гадна Wechat Pay, GLN компаниудтай хамтран олон улсын төлбөр тооцооны гарцыг нээн ажиллаж эхлээд байна. Эдгээрийн үр дүнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар QRay үйлчилгээгээр нийт 75.9 сая гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеэс 48% -иар өссөн бол гүйлгээний үнийн дүнгийн хувьд өмнөх онтой харьцуулахад 78%-иар нэмэгдсэн амжилттай байна.</p>																
3.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</p>	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.</p>																
4.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>																	
	<p>Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй.</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 05/06 тоот “Худалдан авалт хийх зөвшөөрөл олгох тухай” тогтоолын дагуу сонирхлын зөрчил бүхий 1 хэлцэл хийсэн. Үүнийг тодруулбал: QRay төлбөрийн системийн суурь дэд бүтцийн шинэчлэлийн хүрээнд одоогийн сервер, тоног төхөөрөмжийг өргөтгөх чиглэлээр худалдан авалт хийхээр Компанийн хувьцаа эзэмшигч Могоул ХХК-ийн охин компани болох Ай Ти Зон ХХК-тай 166,988,250 төгрөгийн хэлцэл хийсэн.</p>																	
5.	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</p>																	



Иновэйшн Инвестмент ХХК нь СЗХ-ны 2023/11/08-ны өдрийн 551 тоот тогтоолоор IPO хийх зөвшөөрлөө авсан бөгөөд 2023/12/04-ний өдрөөс 2023/12/08-ны хооронд Монголын хөрөнгийн бирж дээр анхдагч зах зээлийн захиалга авч 8.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн. Үүнд:

№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Эзлэх хувь
1	Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт	22.5%
2	Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйлажиллагаа	30.0%
3	Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийгсайжруулах үйл ажиллагаа	15.0%
4	“ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр	25.0%
5	Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах	7.5%

2023 онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 25% буюу “ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр болох 2,080,003,050 төгрөгийг зориулалтын дагуу ККТТ ХХК руу шилжүүлсэн.

2024 оны 6 дугаар сард төлөвлөж байсны дагуу QPau төлбөрийн системийн суурь дэд бүтцийн шинэчлэлийн хүрээнд Суурь дэд бүтцийн сервер, тоног төхөөрөмжийг шинээр худалдаж авах болон одоогийн сервер, тоног төхөөрөмжийг өргөтгөх чиглэлээр худалдан авалт хийхээр нийт 1,061,274,656 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг нийлүүлэгч талуудтай байгуулаад байна. Энэ нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15% буюу “Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийгсайжруулах үйл ажиллагаа”-нд зориулагдах 1,247,994,608 төгрөгөөс зарцуулагдах юм.

2024 оны эхний хагас жилийн байдлаар тус гэрээний дагуу худалдан авалтын урьдчилгаа төлбөрт нийт 609,777,709 төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулаад байна.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

### **Төлөөлөн удирдах зөвлөл**

Инновэйшн Инвестмент ХК нь 2023 оны 12 дугаар сард IPO хийж нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурлаа 2024 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хийсэн. Тус хурлаар ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгосон бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын № 01/03 тоот тогтоолоор дараах гишүүдийг томилсон.

ТУЗ-ийн ердийн гишүүн А.Баттамир  
ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Чулуунсүх  
ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Хатанболд  
ТУЗ-ийн ердийн гишүүн У.Наранбаатар  
ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Анхболд  
ТУЗ-ийн ердийн гишүүн У.Мөнхзул  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Дашцэрэн  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Уянга  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Ганзориг

Компанийн ТУЗ нь Монгол Улсын болон Япон Улсын мэдээллийн технологи, банк, санхүүгийн салбаруудад 10 - 30 гаруй жил ажилласан инженер, бизнес удирдлага, санхүү, хууль эрхзүйн чиглэлээр мэргэшсэн арвин туршлага бүхий гишүүдээс бүрдсэн.

Шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хурлын 05/01 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар А.Баттамир-ыг сонгосон. Мөн тус хурлын 05/03 тоот тогтоолоор хувьцаат компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын шинэчилсэн найруулгыг баталж, мөрдөж ажиллахаар болсон. Энэхүү журам болон холбогдох хуульд нийцүүлэн тус хурлын 05/02 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, гишүүдийг томилсон. Үүнд:

#### **Аудитын хороо:**

ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Хатанболд  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Дашцэрэн  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Уянга

#### **Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо:**

ТУЗ-ийн ердийн гишүүн У.Наранбаатар  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Дашцэрэн  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Ганзориг

#### **Эрсдэлийн удирдлагын хороо:**

ТУЗ-ийн ердийн гишүүн У.Мөнхзул  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Уянга  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Ганзориг



Компани нь өөрийн засаглалын үйл ажиллагаандаа Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, түүний дэргэдэх хороодын бүтэц зохион байгуулалтын үйл ажиллагааг зохицуулсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг дагаж мөрдөж байна. Тус журамд ТУЗ-ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн хурал, хуралдах журам, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь улирал бүр ээлжит хурлаа хуралдаж, эрх үүргийнхээ хүрээнд шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.

#### **Гүйцэтгэх удирдлага**

Компанийн дүрмийн 12 дугаар зүйлд заасны дагуу компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрэм, Компанийн засаглал болон бүтэц зохион байгуулалтын баримт, ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэн ажилладаг. Мөн Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тус тусын харьяалах асуудлуудыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий удирдах түвшний албан тушаалтнууд ажилладаг.

Гүйцэтгэх удирдлагын баг нь дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

	<p>Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх          Санхүү эрхэлсэн захирал Б.Энхболд          Бизнес хөгжил хариуцсан захирал О.Хонгор          Технологи хариуцсан захирал Д.Жанчив          Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал Ц.Гомбодорж          Охин компани болох Дижитал Мерчант Сервисэс ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Гүржав</p>
6.	<p>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</p>
	<p>Тайлант хугацаанд Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон ТУЗ-ийн хурлуудыг хуулийн дагуу хуралдуулж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.</p> <p><b>Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал:</b>          2024/4/28-ны өдөр болсон бөгөөд дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2023 оны санхүү үйл ажиллагааны дүгнэлтийг хэлэлцэн баталсан</li> <li>• Хувьцаат компанийн дүрмийн төслийг баталсан</li> <li>• Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилсон</li> </ul> <p><b>Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал:</b>          Шинээр томилогдсон ТУЗ нь 2024/05/27-ны өдөр анхны хурлаа хийж, дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• ТУЗ-ийн даргыг томилсон.</li> <li>• ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, гишүүдийг томилсон.</li> <li>• ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаа баталсан.</li> </ul> <p>Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь ТУЗ-ын үйл ажиллагааны журам болон Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасан эрх үүргийн хүрээнд тогтмол хурлаа хийж, шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.</p> <p>МХБ болон СЗХ-нд тухай бүр шаардлагатай мэдээллүүдийг хүргүүлэн тайлагнаж байна.</p>
	<p>Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:</p>
Овог, нэр:	<p>Г.Эрдэнэмөнх</p> <p>Албан тушаал: Инновэйшн Инвестмент ХК-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: </p>
	<p>Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:</p>
Овог, нэр:	<p>Б.Энхболд</p> <p>Албан тушаал: Инновэйшн Инвестмент ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал</p> <p>Гарын үсэг: </p>